


Үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд
газар, ой, загасны нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалыг хөгжүүлэх сайн дурын
зөвлөмжийн танилцуулга

Зөвлөмжийн зорилго

2012 онд Дэлхийн хүнсний аюулгүй байдлын хороо (ДХАБХ) газар, ой, загасны нөөцөд нэвтрэх, ашиглах баталгааг сайжруулах сая сая хүний эрхийг хамгаалахад чиглэсэн дэлхийн хэмжээний зөвлөмжийг баталсан. Үндэсний хүнсний аюулгүй байдлын хүрээнд улс орнууд газар, ой, загасны нөөцийн ашиглалтын эрхийн харилцааг зохицуулах хууль, дүрэм журам боловсруулахад баримтлах зарчмуудыг уг сайн дурын зөвлөмжид тусгасан. Одоогийн байдлаар дэлхийн олон орон уг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа бөгөөд Монгол улс тэдний нэг юм.



1. Хүний нэр төр
2. Үл ялгаварлал
3. Тэгш эрх ба шударга ёс
4. Жендерийн эрх тэгш байдал
5. Нэгдмэл, тогтвортой арга зам
6. Зөвлөгөөн, оролцоо
7. Хууль дүрэм
8. Ил тод байдал
9. Хариуцлагатай байдал
10. Байнга боловсронгуй болгох

Зөвлөмжийн хэрэгжилт Монголд

Улаанбаатар хотод 2014 оны 10 дугаар сард уг сайн дурын зөвлөмжийг танилцуулах семинар зохион байгуулагдсан семинараас уг зөвлөмжийг Монгол улсад хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх ажлын хэсэг байгуулах санаачлага гарсан юм. Одоогийн байдлаар Хүнс, Хөдөө Аж Ахуйн яамны стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга хүндэт Л.Чой-Ишээр манлайлуулсан ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.

Хүн Төвтэй Байгаль Хамгаалал ТББ уг зөвлөмжийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор ажлын хэсэгт арга зүйн дэмжлэг үзүүлэх, Монгол хэлний орчуулгыг сайжруулах зэрэг ажлыг гүйцэтгэж байна. Мөн уг зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой удаа дараагийн сургалтуудыг зохион байгуулахад оролцож байна.

Ингээд уг сайн дурын зөвлөмжийг Монгол хэлээр орчуулан цахим хэлбэрээр та бүхэнд хүргэж байна. Нэмэлт мэдээллийг nyansanjav@yahoo.com хаягаар, 99901138 дугаараар төслийн үндэсний зохицуулагч Я.Нарангэрэлтэй холбогдон аваарай.